

Удирдлагын систем удаашрал- аюулын дохио

2019 оны 10-р сар


Танай үйлдвэрлэлийн процессын температур тавилын цэгээс хэтрэх буюу ашиглалтын хүрэнээс давж гарсан байна. Хөргөлтийн хүчин чадал хангалттай байгаа хэдий ч процессыг ашиглалтын хэвийн түвшинд нь буцаах удирдлагын системийн хурд удаан байна. Эцэст нь удирдлагын систем зарчмынхаа дагуу хариу үйлдэх ба температур тавилын цэгтээ буцаж очдог.

Энэ хэвийн үзэгдэл үү? Тийм байх ёсгүй. Удирдлагын хэлхээний угсралт, тохиргоо, ашиглалт сайн бол жигд ажилладаг ба хөргөлтийн шингэн, дулаан, урсгал зэргийг тохируулах хаалтуудыг бага зэрэг өөрчлөх байдлаар процессыг хянадаг.

Дээрх тохиолдлын шалтгаан юу вэ? Энэ нь ямар учиртай вэ?

Боломжит шалтгаанууд:

- **Хяналтын хавхлага** нь зэврэлт эсвэл шингэнээс тунасан хатуу бодис зэрэгт тээглэн гацсан байж болно.
- Хяналтын хавхлага руу нэвтрэх агаар эсвэл доторх урсгал хязгаарлагдсан байж болно. Мэдрэгч бохирдсон, бөглөрсөн байж болзошгүй.
- **Удирдлагын хэлхээний тохиргооны** түвшин тухайн процесст хангалтгүй бөгөөд үүнийг шалгах шаардлагатай байж болно.



Та мэдэх үү?

- Удирдлагатай холбоотой жижиг алдаа нь ноцтой асуудал учруулаагүй хэдий ч систем доголдож эхэлснийг сэрэмжлүүлэх анхан шатны дохио байж болно.
- **Удирдлагын хэлхээний аль нэг эд анги** (мэдрэгч, логик, удирдлагын хэрэгсэл) доголдсон байж болзошгүй. Тус **гурван эд ангийг бүгдийг** нь шалга.
- Удирдлагын системийн алдаа санамсаргүй тохиолдол байх нь ховор. Алдаа арилж болох ч дараа дахин давтагдах, илүү их үр дагавар учруулж болзошгүй. *Ашиглалтын аюулгүй ажиллагааны хүрээнд санамсаргүй тохиолдлууд орших ёсгүй.*
- Хэрэв хэд хэдэн удирдлагын хэлхээнд алдаа үүссэн бол томоохон бөгөөд ихээхэн ноцтой асуудал байгааг илтгэж байж болно. Өнөөдрийн хойрго хандлага нь маргаашийн алдаалуу хөтлөх боломжтой.

Та юу хийж чадах вэ?

- Систем зохих ёсоор ажиллахгүй байгаа бол бусад хүнд тухайн байдал ажиглагдсан эсэхийг лавлаж асуу. Тэдний хариултаас тус асуудал өмнө нь давтагдаж байсан эсэхийг мэдэх боломжтой.
- Ээлж хүлээлцэх журналд тус асуудлын талаар тэмдэглэн бичсэнээр бусад хүнд үүнийг хянах шаардлагатайг анхааруулна.
- Хавхлага энгийн шалтгааны улмаас зохих ёсоор ажиллахгүй байгаа байж болно. Цаг гарган боломжит шалтгаануудыг шалгаж тогтоохыг хичээ (агаарын хоолойноос хий алдагдах, хөргөлтийн системийн алдаа гэх мэт).
- Хэрэв асуудал хэвээр байвал системд үзлэг хийлгэхийн тулд ажлын захиалга үүсгэ. Зөвхөн хяналтын хавхлага бус, удирдлагын хэлхээний аль нэг эд анги гэмтсэн байж болно.

Удирдлагын системийн алдаа нь аюулыг сэрэмжлүүлэх дохио юм. Ноцтой асуудал үүсэхээс өмнө хариу арга хэмжээ ав.